



“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. “БиДиСЕК ҮЦК” ХК /цаашид “Компани” гэх/-ийн Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичиг /цаашид “Баримт бичиг” гэх/-ийн зорилго нь компанийн оролцогч талууд буюу хувьцаа эзэмшигч, ажилтан, хэрэглэгч, харилцагч, бэлтгэн нийлүүлэгч, зохицуулагч байгууллагуудтай хэрхэн харилцах, хамтын ажиллагааг тодорхойлоход оршино.

ХОЁР. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 2.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, тэдгээрийн дагуу тодорхой ажил зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд компанийн эрх бүхий албан тушаалтнаар шийдвэр гаргуулан хариу өгөх үйл ажиллагааг зохион байгуулах замаар бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.2. Компани хөрөнгө оруулагчидтай зөвшилцөх, хамтран ажиллахдаа зах зээлийг урвуулан ашиглах, үгсэн хуйвалдахыг хориглосон хуулийн зохицуулалтыг зөрчихөөс сэргийлнэ.
- 2.3. Компани ажилтантай байгуулах Хөдөлмөрийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод журамд компанийн болон, ажилтны хүлээх үүрэг хариуцлагыг тусгаж, хэрэгжилтийг хянах тогтолцоо бүрдүүлэн ажиллана.
- 2.4. Компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа хууль бус, ёс зүйгүй үйлдлийн талаар комплайнсын нэгж/ажилтан хянаад холбогдох саналыг Гүйцэтгэх удирдлагад чөлөөтэй мэдээлж шийдвэрлүүлэх эрхтэй байх бөгөөд шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх удирдлага ТУЗ-д мэдэгдэн шийдвэрлүүлнэ.
- 2.5. Комплайнсын нэгж/ажилтан нь ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.
- 2.6. Компани нь хөрөнгийн зах зээлийг хянах зохицуулах байгууллагатай хариуцлагатай хөрөнгө оруулалт болон компанийн засаглалын зарчмыг хэвшүүлэх асуудлаар хамтран ажиллах, санал солилцохыг эрхэмлэнэ.
- 2.7. Зохицуулах байгууллагаас санаачлан зохион байгуулах хэлэлцүүлэг, семинар зэрэг арга хэмжээнд идэвхтэй оролцох, туршлага мэдээлэл солилцож ажиллана.
- 2.8. Компанийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахдаа цахим хуудсыг холбоо тогтоох, мэдээлэл түгээх зэргээр үр дүнтэйгээр ашиглана.

ГУРАВ. Оролцогч талууд

- 3.1. Компанийн оролцогч талуудын хооронд үүсэх харилцаа, хамтын ажиллагаанд Гүйцэтгэх удирдлага хяналт тавьж, холбогдох албан тушаалтны хамт

хэрэгжүүлнэ.

- 3.2. Хувьцаа эзэмшигчийг компанийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэгч гэх үүднээс түүний хууль тогтоомжид заасан эрхийг хүндэтгэн тэгш хандаж, компанийн талаар мэдээлэл авах болон бусад эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрэн хангана.
- 3.3. Ажилтныг компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гэх үүднээс түүнтэй харилцахдаа хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан эрх хэмжээ, үүрэг хариуцлагын хүрээнд харилцана.
- 3.4. Харилцагчийг компанийн орлогыг бүрдүүлэгч гэх үүднээс тэдний сэтгэл ханамж, үр өгөөжтэй байдал зэргийг бүрэн хангах зорилго бүхий байгууллагын соёлыг бүрдүүлж ажиллана.
- 3.5. Бэлтгэн нийлүүлэгчийг компанийн үйл ажиллагааны эх үүсвэр /түүхий эд, бараа материал/-ээр хангагч гэх үүднээс гэрээний дагуу хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлнэ.
- 3.6. Компани нь холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг бүрэн хангаж, зохицуулагч, төрийн байгууллагад тайлан мэдээг цаг тухайд нь хүргүүлнэ.
- 3.7. Компанийн оролцогч талуудтай харилцах харилцаанд гарсан зөрчил, маргааныг эв дүйгээр тохиролцож, харилцан буулт хийх замаар шийдэхийг зорин ажиллана.
- 3.8. Харилцан тохиролцож шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. Бусад

- 4.1. ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.